

## **“ХҮНДЭТ ДОКТОР”, “СУДАЛГААНЫ ПРОФЕССОР” ЦОЛ ОЛГОВ**

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөл ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Олег Михайлович Дерковский, Монгол Улсын нэртэй дипломатч, улс төрч, орчуулагч Ц.Гомбосүрэн, БХЯ-ны Стратегийн судлалын хүрээлэнгийн захирал, профессор Л.Моломжамц нарт “Хүндэт доктор”-ын цол өргөмжилж, ахмад түүхч, судлаач Ц.Хандсүрэнд “Судалгааны профессор” цол хүртээхээр шийдвэрлэсэн байна. Уг цол хэргэмийг нь 2004 оны 12 дугаар сарын 28-нд ШУА-ийн төв байранд болсон ёслолын ажиллагаан дээр Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, шинжлэх ухааны доктор, профессор Л.Хайсандай ОХУ-ын элчин сайд Олег Михайлович Дерковский болон Монголын эрдэмтэн, судлаач Ц.Хандсүрэн, Ц.Гомбосүрэн, Л.Моломжамц нарт гардуулан өгч, баяр хүргэж, амжилт хүсэв.

Доктор, профессор Л.Хайсандай энэ хүмүүст эрдмийн ийм өндөр хүндтэй цол хэргэм хүртээх болсон талаараа хэлэхдээ: “Элчин сайд О.М.Дерковский бол Орос-Монголын харилцааг бэхжүүлэх, Монголд орос судлалыг хөгжүүлэх үйлсэд бодитой, тодорхой хувь нэмрээ оруулж байгаа хүн. Манай гурван эрхмийн тухайд гэвэл тэд бүгд л Монгол Улсын түүх, гадаад харилцаа, олон улс судлалын олон арван бүтээл туурвилаараа өөрийн оронд төдийгүй гадаадад өндөр нэр хүндийг олсон хийгээд эрдэм ухаан нь тэгширсэн гавьяатай хүмүүс байгаа юм” хэмээн онцлон үнэлж тодорхойлов.

## **ШУА-ИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

### **Зарим хүмүүст “Судалгааны профессор”, “Хүндэт доктор” цол олгох ба өргөмжлөх тухай**

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2001 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталгаажсан Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дүрмийн гуравдугаар зүйлийн 3-н “В”, “Г”, заалтыг үндэслэн Эрдмийн Зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Монголын түүх судлал, мөн Япон, Хятад судлалаар олон арван бүтээл туурвиж, олон нийтийн хүртээл болгосон манай ахмад ажилтан, нэртэй түүхч, судлаач Цэндийн Хандсүрэнд “Судалгааны профессор” цол олгосугай.

2. Орос-Монголын найрамдалт харилцааг бэхжүүлэх, орос судлалыг Монголд хөгжүүлэх үйлсэд их хувь нэмэр оруулсан Монгол Улсад суугаа ОХУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Олег Михайлович Дерковский, Монголын гадаад харилцаа, олон улс судлалыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж буй Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, улс төрч, орчуулагч Цэрэнпилийн Гомбосүрэн, Монгол Улсын аюулгүй байдал, гадаад орчин, стратеги судлалыг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулж буй БХЯ-ны Стратегийн судлалын хүрээлэнгийн захирал, профессор Лувсангомбын Моломжамц нарт “Хүндэт доктор”-ын цол өргөмжилсүгэй.

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Л.ХАЙСАНДАЙ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДОКТОР (Ph.D)

Д.ШҮРХҮҮ

## ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

1. 2000 оны 1 дүгээр сараас Монгол Улсад суугаа ОХУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Олег Михайлович Дерковский нь манай орны эрдмийн байгууллага, хамт олон, тухайлан тус хүрээлэнтэй нягт харилцаа холбоотой ажиллаж, “ОХУ-аас Азийн чигт явуулж буй бодлого, Орос-Монголын харилцаа: тулгамдсан асуудал” сэдвээр нөхөрсөг уулзалт- яриа хийж, лекц уншиж, санал бодлоо солилцож байснаас гадна “Даяаршил ба Монгол Улс”, “Тегеран-60”, “Төв Азийн олон улсын харилцаан дахь ОХУ-ын геополитикийн ашиг сонирхол” зэрэг эрдэм шинжилгээний хэд хэдэн сонирхолтой өгүүлэл бичиж, Монголын ба Оросын сэтгүүлүүдэд нийтлүүлсэн ба И.Я.Коростовцын бичсэн “От Чингисхана до Советской Республики” хэмээх архивын нэн ховор чухал материал бүхий номыг тус хүрээлэн, Буриадын хүрээлэнтэй хамтран хэвлэн нийтлүүлэх асуудлыг санаачилж, уг номыг редакторлахад биечлэн оролцож, өмнөх үгийг нь бичсэн юм.

2. Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, улс төрч, орчуулагч Цэрэнпилийн Гомбосүрэн нь “XX зууны Монгол Улсын гадаад харилцааны түүхэн тойм” бүтээлийг дипломатч М.Дүгэрсүрэний хамт бичиж, “Ардчилсан хувьсгалын эхэн үеийн гадаад бодлогын шинэчлэл”, “Олон тулгуурт гадаад бодлого”, “Аюулгүй байдал, гадаад бодлогын зарим асуудал” зэрэг улс-төр-судалгааны олон арван өгүүлэл,

илтгэл нийтлүүлсний дээр тус хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн З.Бжезинскийн “Шатрын аварга хөлөг ном”-ыг орос, англи хэлнээс доктор К.Дэмбэрэлийн хамт орчуулж, нийтийн хүртээл болгосон. Мөн тэрээр нийтдээ улс төрийн ба уран зохиолын томоохон хэмжээний 12 номыг орос хэлнээс монгол хэлнээ хөрвүүлж, “Бидний монголчууд” “цувралыг эрхлэн 25 дэвтрийг одоогоор хэвлүүлээд байна.

3. БХЯ-ны Стратегийн судлалын хүрээлэнгийн захирал, профессор Лувсангомбын Моломжамц нь Монгол Улсын батлан хамгаалал, цэргийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үйлсэд онц идэвхи зүтгэл гарган ажиллаж буйн хамт түүний шууд удирдлагын дор батлан хамгаалахын анхны ба хоёр дахь цагаан номыг бэлтгэн хэвлүүлж, Зүүн Хойт Ази болон өөрийн орны аюулгүй байдал, стратегийн асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хэд хэдэн бага хурал амжилттай зохион байгуулсан. Профессор Л.Моломжамц нь Монголын гадаад харилцаа, олон улс судлалын чиглэлээр “Их гүрнүүдийн түншлэл ба Монгол Улсын аюулгүй байдал”, “АНУ, БНХАУ-ын харилцаа ба Монгол Улс”, “ОХУ-ын дотоод байдал, Азид явуулж буй бодлогын тухай”, “Геополитикийн тэмцэл ба энхийг сахиулах операцийн тухай”, “Орос, Хятадын цэргийн харилцааны төлөв, түүний Монголд нөлөөлөх нь”, “Олон Улсын терроризм: Монголын Улсын гадаад орчин” зэрэг эрдэм шинжилгээний 50 гаруй өгүүлэл, илтгэл, 4 ном товхимол бичиж дотоод, гадаадад нийтлүүлсэн байна.

4. ШУА-ийн системд Дорно дахин судлалын анхны эрдмийн байгууллага үүссэн байгуулагдсан тэр цагаас эхлэн ажилласан манай ууган эрдэм шинжилгээний ажилтан Ц.Хандсүрэн нь “Жужаны хаант улсын түүхийг дагнан судлаж, судалгааны эргэлтэнд анхлан оруулсан түүхч бөгөөд мөн Япон, Хятад судлалаар олон арван бүтээл туурвисаны дотор тухайлбал “Өвөр Монголын Өөртөө засах орон” хамтын бүтээлийн 1911-1947 оны үеийн хэсгийг, “Төвд орон, түүний байдал, төлөв”, “Дагуурын зан заншил”, “Япон орон” зэрэг өгүүлэл, товхимол бичиж нийтлүүлснээс гадна япон, хятадын эрдэмтэдийн 10 шахам бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлж хэвлүүлсэн. Эдгээрээс гадна өөрийн эцэг Цэнд гүний орчуулсан “Монголын Нууц Товчоо”-г улам нягтлан боловсруулж “Цэнд гүн ба Монголын нууц товчоо” нэг ба хоёрдугаар дэвтрийг эрхлэн хэвлүүлсэн байна.